

---

**Энэ удаагийн ургацын баяраар өөрийн болон гэр бүл, ойр дотны хүмүүсийнхээ аюулгүй байдлын төлөө гэртээ байж, уулзахаас илүүтэйгээр утсаар мэндчилгээ дэвшүүлнэ үү.**

---

[Ургацын баярын үеэр халдварт өвчнөөс онцгойлон сэргийлэх хугацаа: 9.28 ~ 10.11 (2 долоо хоног), хөл хөдөлгөөнөө багасгахыг зөвлөж байна]

**1 Засгийн газраас ургацын баярын үеэр халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.**

- Хаа нэг тийшээ явах бол хувийн унаагаар зорчих, нийтийн тээврээр үйлчлэхдээ хоол хүнс хэрэглэхээс татгалзах, хот хооронд зорчихдоо түр амрах газраар үйлчлүүлэх цагаа багасгах
- (Нийтийн тээвэр) Заавал амны хаалт зүүж, хоол хүнс хэрэглэхээс татгалзах
- (Хурдны зам дагуу байрлах түр амрах газар) Ширээ сандал хооронд хаалт хийх, нэг эгнээнд суухаар суудлыг байрлуулах

**2 Ургацын баярын үеэр халдварын өндөр эрсдэлтэй ажлын байранд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлнэ.**

- (Их дэлгүүр, худалдааны төв гэх мэт) Ажилтан болон үйлчлүүлэгч амны хаалт зүүх, хүнсний бүтээгдэхүүний амталгаа явуулахгүй байх
- (Ахмад настны сувиллын газар, сувиллын эмнэлэг) Гарцаагүй тохиолдолд урьдчилан цаг авсны дараа ойртохгүйгээр уулзаж эргэлт хийх

**3 Урт амралтын үеэр халдварт авчнөөс урьдчилан сэргийлэх эмнэлгийн үйлчилгээ, арга хэмжээг тасралтгүй явуулна.**

- (Гадаадын орноос орж ирэх эрсдэлийг бууруулах) Гадаадын орноос ирж буй бүх зорчигчдод 3 хоногийн дотор оношилгоо шинжилгээ хийж, 14 хоногийн хугацаанд тусгаарлалтанд байлгана.
- (Утсаар зөвлөгөө өгөх) Өвчнөөс урьчилан сэргийлж хянах ерөнхий газар, дуудлагын төв (☎1339) 24 цагаар ажиллана.
- (Оношилгоо шинжилгээ) Баярын урт амралтын үеэр үзлэг шинжилгээ хийлгэх боломжтой эмнэлгийн талаарх мэдээлэл болон яаралтай тусламж зэрэг онцгой байдлын эмнэлгийн үйлчилгээг үзүүлнэ.

< Орчуулгыг Данүри 1577-1366 хийв..>